

## ГАРЧИГ

<i>НЭГ. 2022 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i> .....	3
<i>1.1. Төслийн ерөнхий мэдээлэл</i> .....	3
<i>ХОЁР.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i> .....	5
<i>ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i> .....	9
<i>ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i> .....	9
<i>ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i> .....	9
<i>ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i> .....	9
<i>ДОЛОО. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i> .....	9
<i>НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i> .....	9
<i>ЕС. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i> .....	9
<i>АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ</i> .....	12
<i>АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ АЖЛЫН БИЕЛЭЛТ</i> .....	15
<i>ДҮГНЭЛТ</i> .....	16

## ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

<i>Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн солбилцол.....</i>	<i>3</i>
---	----------

## ЗУРГИЙН ГАРЧИГ

<i>Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн топо зураг 1:50000 (ArcGIS).....</i>	<i>4</i>
<i>Зураг 2. Ус ашиглуулах дүгнэлт .....</i>	<i>6</i>
<i>Зураг 2. Ус ашиглуулах дүгнэлт .....</i>	<i>7</i>
<i>Зураг 4. Ус ашиглуулах дүгнэлт .....</i>	<i>8</i>
<i>Зураг 3. Хог хаягдлын гэрээ.....</i>	<i>10</i>
<i>Зураг 4. Хог хаягдлын гэрээ.....</i>	<i>11</i>
<i>Зураг 5. Агаарын чанарын шинжилгээ.....</i>	<i>12</i>
<i>Зураг 6. Агаарын чанарын шинжилгээ.....</i>	<i>13</i>
<i>Зураг 7. Хөрсний хүнд металлын шинжилгээний хариу.....</i>	<i>14</i>
<i>Зураг 8. Усны химийн шинжилгээний хариу.....</i>	<i>15</i>

## НЭГ. 2022 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

**Төслийн нэр:** “Цагаан залаатын хүрэн нүүрсний ордыг ил уурхайн аргаар ашиглах” төсөл

**Төсөл хэрэгжүүлэгч:** “Дорнын чулуулаг” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011030019, Регистрийн дугаар: 5070287, Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл: MV-017432

**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 220-н мянгат, 4-19 тоот. Утас: 9905-2986

**Төслийн байршил:** “ДОРНЫН ЧУЛУУЛАГ” ХХК-ийн эзэмшдэг MV-017432 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Цагаан залаатын хүрэн нүүрсний орд нь Улаанбаатар хотоос зүүн урагшаа 650 км, Сүхбаатар аймгийн төв Баруун-Урт хотоос зүүн урагшаа 70 км, Сүхбаатар сумаас урагшаа 25 км, Асгат сумаас зүүн зүгт 35 км зайд оршино.

Газар зүйн байршлын хувьд Дорнод Монголын өмнөд хэсгийн хээр талын өмнөд Хэрлэнгийн өргөгдлийн бүсэд орших ба 1:100000 харьцалтай байр зүйн зургаар L-49-60, L-50-49 хавтгайнуудын уулзварт байрлалтай. Засаг захиргааны нэгжийн хуваариар Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Асгат сумдын нутагт байрладаг.

Талбайн солбицлын цэгүүд:

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн солбилцол


Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
1	114° 1' 26"	46° 22' 45"
2	114° 0' 2.48"	46° 22' 45"
3	114° 0' 2.48"	46° 24' 21.75"
4	114° 1' 26"	46° 24' 21.75"



## ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШЛЫН ЗУРАГ

1:200,000

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум, Асгат сум



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн топо зураг 1:50000 (ArcGIS)

2022 онд уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу 11 445.37 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 2 820.0 мян.тн нүүрс олборлохоор төлөвлөсөн. Гэсэн хэдий ч хил гаалийн асуудлаас үүдэн манай компани уулын ажлын төлөвлөгөөндөө хүрч ажиллаж чадаагүй бөгөөд 2022 оны 10-р сарын байдлаар хөрс хуулалтын ажил хийгдэж байгаа бөгөөд нүүрс олборлолтын ажил явагдаагүй болно.

### ХОЁР.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт
1	Уурхай орчимд тоосжилт үүсэх	Дотоод тээврийн авто замыг тоосжилтоос сэргийлж усалж байх	Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах ажлыг хуваарийн дагуу тогтмол гүйцэтгэсэн
2		Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх	Орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд ус, хөрсний дээж авч лабораторид шинжлүүлсэн.
1	Ашиглаж буй усны чанар муудах, хүрэлцээ бага байх	Ус ашиглах дүгнэлтийг жил бүрийн эхэнд гаргуулах	Ус ашиглах гэрээ байгуулж, ус ашиглуулах зөвшөөрөл авч ажилласан.
2		Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь тогтмол хугацаанд төлөх	Ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлж ажилласан.
3		Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд усны дээж авч лабораторид шинжлүүлсэн.
1	Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс овоолго, уурхайн тосгон, бусад байгууламжуудын дор дарагдаж, элэгдэл, эвдрэлд өртөнө.	Үржил шимт хөрсний овоолгод ялзмаг, механик бүрэлдэхүүн, давсны агууламж, хөдөлгөөнт элементийн шинжилгээг хагас жил тутамд хийлгэх	Шимт хөрсийг тусгай талбайд овоолго үүсгэн хадгалсан. Хөрсний шинжилгээ хийлгэсэн.
2		Эрүүл газарт хөрс хуулах, овоолго байгуулах бүрт талбайн үржил шимтэй хөрсийг хуулан шимт хөрсний овоолгод хадгалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд эргүүлж ашиглах зорилгоор овоолго үүсгэж, механик өгөршлөөс хамгаалах	
3		Үржил шимт хөрсний овоолгод ялзмаг, механик бүрэлдэхүүн, давсны агууламж, хөдөлгөөнт элементийн шинжилгээг хагас жил тутамд хийлгэх	
1	Шимт хөрсний овоолго үүсгэх зэрэг ажлын үед ургамал устгах, дарагдах, талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-т заасны дагуу өөрийн эзэмшлийн газрын 10 хувиас доошгүй талбайд мод тарьж зүлэгжүүлэх	Уурхайн талбай орчимд
2		“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд орон нутагт тарих модны тооцоо судалгааг хийж, орон нутагтай хамтран ажиллах гэрээнд тусган хэрэгжүүлэх	



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ  
УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН  
ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН  
ЗАХИРГАА

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,  
Найрамдал хотхон, Утас/Факс: (976) 7054 3599,  
И-мэйл: umardgobi14@gmail.com, Вэбсайт: www.gobiwater.mn

2022.06.08 № 115  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“ДОРНЫН ЧУЛУУЛАГ” ХХК-Д

Танай байгууллагын албан хүсэлтийн дагуу  
2022 оны уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөө,  
ТЭЗҮ-г үндэслэн 2022 оны ус ашиглуулах дүгнэлтийг  
гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг: Сүхбаатар Байгаль орчин, аялал  
жуулчлалын газарт

Хавсралт хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.САРАНТУЯА



Зураг 2. Ус ашиглуулах дүгнэлт

**УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА  
УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ**

2022 оны 06 -р сарын 08-ны өдөр

Дугаар: 07

Чойр хот

**1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар:**  
“ДОРНЫН ЧУЛУУЛАГ” ХХК, Захирал Ц.Адъяаотгох, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Санкт Петербург 225тоот. Улсын бүртгэлийн дугаар:9011030019. Регистрийн дугаар: 5070287 Утас: 99285009

**2. Төслийн нэр, байршил:**

Улаанбаатар хотоос зүүн урагшаа 650км, Сүхбаатар аймгийн төв Баруун-Урт хотоос зүүн урагшаа 70км, Сүхбаатар сумаас урагшаа 25км, Асгат сумаас зүүн зүгт 35км, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт оршино.

**3. Төсөл хэрэгжүүлэгч:**

“ДОРНЫН ЧУЛУУЛАГ” ХХК

**4. Тусгай зөвшөөрлийн болон талбайн координат / х,у /:**

Тусгай зөвшөөрлийн дугаар MV-017433

Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг	Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
1	114° 01' 30.0"	46° 30' 35.0"	9	113° 59' 18.05"	46° 24' 21.71"
2	114° 01' 30.0"	46° 30' 00.0"	10	113° 59' 18.05"	46° 24' 56.0"
3	114° 03' 50.0"	46° 30' 00.0"	11	113° 58' 44.0"	46° 24' 56.0"
4	114° 03' 50.0"	46° 28' 30.0"	12	113° 58' 44.0"	46° 26' 48.0"
5	114° 05' 02.44"	46° 28' 30.0"	13	113° 59' 30.0"	46° 26' 48.0"
6	114° 05' 02.46"	46° 26' 25.0"	14	113° 59' 30.0"	46° 27' 35.0"
7	114° 03' 34.0"	46° 26' 25.0"	15	113° 59' 09.0"	46° 27' 35.0"
8	114° 03' 21.73"	46° 24' 21.73"	16	113° 59' 09.0"	46° 30' 35.0"

**5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт:**

Нүүрсний ил уурхай.

**6. Үйлдвэрийн техник, технологи / ажиллах горим, хүчин чадал /:**

Экскаватор /Hyundai-4700LA/ 1ш, Утгуурт ачигч /ZL-50E/ 1ш, Автосамосвал /Howo ZZ3257 / 4ш, өрмийн машин ZGYX-430 1ш ашиглана.

Уурхайд нийтдээ 254 хүн, 340 хоног ажиллана. /ҮАТ-2022/

**7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:**

2022 онд 1.5 сая.тн нүүрс олборлоно.

**8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ / шоо.метр/:**

Уурхайн шүүрлийн ус.

**9. Усны барилга байгууламжууд / нэр, хүчин чадал, барилга байгууламжийн хийц /:**

Мэдээлэл байхгүй.

**10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур / насосны хүчин чадал, марк /:**

Унд ахуйн хэрэглээг 2.0 л/с ундаргатай өөрийн эзэмшлийн 1 худгаас хангана.

**11. Дамжуулах байгууламж / шугам сүлжээний урт, диаметр /:**

Мэдээлэл байхгүй.

**12. Хэрэглэгчээс гарах хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин:**

Унд-ахуйн бохир усыг хөрсөнд нэвчүүлэн зайлуулна.

**13. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлэн ашиглах даалгавар:**

Уурхайн мухлагаас шавхан зайлуулж буй усыг зам талбайн усалгаа, тоосжилт дарахад ашиглана.

**14. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:**

Зураг 3. Ус ашиглуулах дүгнэлт

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг “МОНСЛОВ” ХХК 2019 онд гүйцэтгэсэн.

**15. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцоход:**

2022 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, ТЭЗҮ-ийн 30-37 хуудасны мэдээллийг үндэслэв.

$$254 \text{ хүн} \times 50.0 \text{ л} = 12.7 \text{ м}^3/\text{хон}$$

$$12.7 \text{ м}^3/\text{хон} \times 300 \text{ хон} = 3810.0 \text{ м}^3/\text{жил} - \text{Унд ахуйн хэрэгцээнд}$$

$$1.0 \text{ л/сек} \times 86400/1000 \times 120 \text{ хон} = 10'368.0 \text{ м}^3/\text{жил} - \text{нийт шавхан зайлуулах усны хэмжээ}$$

Шавхан зайлуулах усыг зам, талбай, ногоон байгууламжийн усалгаанд ашиглана.

**Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны төлбөрийн хэмжээ:**

Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 326 дугаар тогтоолын 2-р хавсралтын дагуу унд ахуйн зориулалтаар ашиглах **3810.0 м<sup>3</sup>** усыг байгалийн нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлнө.

Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 326 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 327 дугаар тогтоолыг үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

Шавхан зайлуулах усны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ усны нөөц ашигласны төлбөр: } 3700 \text{ төг/м}^3 \times 0.15 \times 1.6 = 888 \text{ төг}$$

-3700 төг/м<sup>3</sup>-Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи, эдийн засгийн суурь үнэлгээ.

-(15%)-Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 7 (в)-д заасан хувь, хэмжээ.

-1.6 -Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын дагуу ус шавхан зайлуулахад тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр.

$$10'368.0 \text{ м}^3 \times 888 \text{ төг/м}^3 = 9'206'784.0 \text{ төг}$$

Нийт: **9'206'784.0 төг** /Есөн сая хоёр зуун зургаан мянга долоон зуун наян дөрвөн төгрөг/

**16. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмж:**

- ✓ Усны тухай хуулийн 28.6, 29.1 дахь заалтуудыг үндэслэн Сүхбаатар аймгийн Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газраас зөвшөөрөл авч гэрээ байгуулна.
- ✓ Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглавал “Зөрчлийн тухай” хуулийн дагуу арга хэмжээ авахыг анхааруулж байна.
- ✓ “Усны тухай” хуулийн 31.2-т зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар өсгөн тооцож төлөхөөр заасныг анхаарч, жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө, календарьчилсан графикийг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх.
- ✓ Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай мэдээ тайлан, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээг 2022 оны 12 дугаар сарын 25-ны дотор “Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар”-ын захиргаанд ирүүлэх.

**ДҮГНЭЛТ ГАРГАСАН:**

УГГ-ХДТСГЗ-НЫ МЭРГЭЖИЛТЭН

О.БАТХҮҮ

*Зураг 4. Ус ашиглуулах дүгнэлт*



## **ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022 оны уулын ажлын төлөвлөгөөнд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил тусгагдаагүй болно.

### **ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Сүхбаатар болон Асгат сумын нутаг дэвсгэрт байрлах “Дэлгэр овоо” нэртэй талбайд 0.12 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

### **ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээг уурхай хаагдах үед хаалтын зардалд тусгаж өгсөн тул 2022 онд энэ чиглэлийн үйл ажиллагаа хийгдээгүй болно.

### **ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

“Дорнын чулуулаг” ХХК-ны тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна.

### **ДОЛОО. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**


Уурхайн үйл ажиллагаанд ямар нэгэн химийн бодис ашиглахгүй. 2022 онд уулын ажлын төлөвлөгөөндөө хүрч ажиллаж чадаагүй бөгөөд өрөмдлөг тэсэлгээний ажил огт явагдаагүй болно.

### **НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Осол эрсдэл, удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.

### **ЕС. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд хог хаягдлын гэрээг байгуулан, хуваарийн дагуу хог хаягдлыг тогтмол тээвэрлүүлж, төлбөрийг төлж хамтран ажилласан.



**ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ариун цэврийн тухай хуулийн 17-р дугаар зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 8.4, 9.2, 20.1, 20.2 дахь заалтуудыг тус тус үндэслэв.

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх булах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллаж амьдрах орчныг бий болгоход оршино.

**Хоёр. Гэрээ байгуулагч талууд**

Нэг талаас Сүхбаатар аймгийн Асгат сумын ЗДТГ-ыг төлөөлж Засаг даргын орлогч ажилтай Л.Төгөлдөр нөгөө талаас Дорнын чулуулаг ХХК-ийн /Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг 1 дүгээр хороо Санктпетербург төв 220 тоот Улсын бүртгэлийн 9011030019 гэрчилгээтэй Уурхайн дарга ажилтай Б.Үнэнбат нар харилцан тохиролцож 2022 оны 08 сарын 01 өдрөөс 2022 оны 12 сарын 31-ийг хүртэл хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

**Гурав. Төлбөр тооцсон байдал:**

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн А/368 тоот тушаал, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 7 сарын 19-ний өдрийн 192,А/243 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, Асгат сумын ИТХ-ын 2021 оны 07 сарын 29-ны 04 тоот тогтоолыг үндэслэн нэг сарын төлбөр 200.000 /мянган төгрөг/-өөр тооцож

Ажиллах хугацаа 5 сар .....

Сарын төлбөр 200.000.....

Жилийн нийт төлбөр 1.000.000.....

**Дөрөв. Сумын ЗДТГ эрх**

1. Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын хууль, Ариун цэврийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах.

2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдал гаргасны төлбөрийг төвлөрүүлэх

3. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавих

4. Хог хаягдалыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулж хэрэгжилтэнд хяналт тавих.

*Зураг 5. Хог хаягдлын гэрээ*

**Тав:Иргэн, ААН байгууллагын эрх үүрэг**

1.Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн, хуурай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх.

2.Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө улирал бүрийн сүүл сарын 15-ны дотор гэрээнд зааснаар төрийн сан банк 100120100947 тоот дансанд тогтмол шилжүүлж байна.

3.Хог хаягдлыг ангилан ялгаж байх

4.Ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэж тээвэрлэх, хог хаягдлын талаарх дүрэм журам стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байхад анхаарах.

5.Үйлдвэр үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ, бусад мэдээллийг сумын захиргаанд мэдээлж байх.

6.Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдээллийг ажилтнуудад эзэмшүүлж, сургалт сурталчилгаа явуулах, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах.

7.Оршин суугаа газар орчмын хог хаягдлыг цэвэрлэх, олон нийтийг хамарсан ажилд оролцох.

8.Хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах.

9.Үүссэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээллэх.

**Зургаа:Гэрээний хариуцлага**

6.1.Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө удаан хугацаагаар төлөөгүй болон ил задгай хог шатаасан, зориулалтын бус газар хог хаягдал хаясан нөхцөлд өр авлагыг барагдуулах ба учруулсан хохирлыг арилгах шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгууллагад хандан хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.

6.2.Аж ахуйн нэгж байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүр шийдвэрлэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**



**Дорнын чулуулаг ХХК-ийн**

.....  
/Л.Үнэнбат/  
Утас:98280409

*Зураг 6. Хог хаягдлын гэрээ*

## АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

2022 онд рчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд уурхай орчмоос хөрсний дээж авч шинжлүүлсэн.

**СҮХБААТАР АЙМАГ**  
**СҮХБААТАР УС ЦАГ УУР, ОРЧНЫ**  
**ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ**  
**ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ**  
**ТӨВ ТБАГУТУГ**


Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум 7-р баг  
Утас: 70518201-94771766  
E-Mail: [sb-tsaguur2020@gmail.com](mailto:sb-tsaguur2020@gmail.com)


**ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН**

Дугаар он/код	№2022/08
Сорьц авсан газрын нэр хаяг, утас:	:Сүхбаатар аймаг, Асгат сум “Дорнын чулуулаг”ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал	:Н.Мөнхбаяр БОШЛ-ийн эрхлэгч
Сорьцын хэмжээ, төрөл	:Агаар MNS
Сорьц авсан огноо	:2022.06.06
Шинжилгээний аргын стандарт	:MNS
Лабораторид ирсэн	:2022.06.08
Шинжилгээ хийсэн огноо	:2022.06.08
Хуудасны тоо	:1/1

**Үр дүн:**

Шинжилгээний аргын стандарт	Сорьц авсан цэг	Үр дүн		Хэмжилт хийсэн хугацаа
		NO <sub>2</sub> (мг/м <sup>3</sup> )	SO <sub>2</sub> (мг/м <sup>3</sup> )	
MNS4585:2016	A-1 Уурхайн зүүн хойд тал	0.015	0.011	20мин
	A-2 Атобол урд тал	0.024	0.011	20мин
	A-3 кемп баруун тал	0.016	0.013	20мин
Стандарт		0.200	0.450	

Шинжилгээ гүйцэтгэсэн техникч:  Б.Саранцэцэг/  
(гарын үсэг) (нэр)

Хянан баталгаажуулсан лабораторийн эрхлэгч:  Н.Мөнхбаяр/  
(гарын үсэг) (нэр)

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.

Зураг 7. Агаарын чанарын шинжилгээ

СҮХБААТАР УС ЦАГ УУР ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ


Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум 7-р баг  
Утас: 70518201, 94771766  
E-Mail: [sb.tsaguur2020@gmail.com](mailto:sb.tsaguur2020@gmail.com)

ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН


Дугаар он/код № 2022/08  
Сорьц авсан газрын нэр хаяг, утас, : Сүхбаатар аймаг, Асгат сум  
“Дорнын чулуулаг”ХХК  
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Н.Мөнхбаяр БОШЛ-ийн эрхлэгч  
Сорьцын хэмжээ, төрөл : Агаар TSP  
Сорьц авсан огноо : 2022.06.06  
Шинжилгээний аргын стандарт : MNS  
Лабораторид ирсэн : 2022.06.08  
Шинжилгээ хийсэн огноо : 2022.06.08  
Хуудасны тоо : 1/1

Үр дүн:

Шинжилгээний аргын стандарт	Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж	Үр дүн			Стандарт	Хэмжилт хийсэн хугацаа
		TSP их утга (мг/м <sup>3</sup> )	TSP бага утга (мг/м <sup>3</sup> )	TSP дундаж утга (мг/м <sup>3</sup> )		
MNS4585:2016	A-1 Уурхайн зүүн хойд тал	0.398	0.000	0.017	0.500	20мин
	A-2 Атобол урд тал	0.100	0.003	0.024	0.500	20мин
	A-3 кемп баруун тал	0.085	0.003	0.013	0.500	20мин

Шинжилгээ гүйцэтгэсэн техникч:  Б.Саранцэцэг/

(гарын үсэг) (нэр)

Хянан баталгаажуулсан лабораторийн эрхлэгч:  Н.Мөнхбаяр/

(гарын үсэг) (нэр)

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.

Зураг 8. Агаарын чанарын шинжилгээ



**MNAS**  
Accreditation  
system  
T1-B8  
MNS ISO-IEC

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043 Улаанбаатар, Чингисийн өргөн чөлөө,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас:11-341818  
E-mail: clem@namem.gov.mn



**БАЙГАЛЬ**  
ОРЧИН ХЭМЖИЛГЭЭНИЙ ТӨВ ЛАБОРАТОРИ

---

**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/ №	: 2022/ 509-510
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Дорнын чулуулаг” ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал	: Н.Мөнхбаяр
Дээжийн тоо, төрөл	: 2, хөрсний сорьц
Хүлээн авсан огноо	: 2022.09.27
Дээжийн тодорхойлолт	: Сүхбаатар аймаг –Сүхбаатар сум
Шинжилгээний аргын стандарт	: САЗ Х:2016
Шинжилсэн огноо	: 2022.09.28
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн:	

№	Сорьц авсан цэгийн нэр	Кадьми (Cd)	Хар тугалга (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Кобальт (Co)	Стронци (Sr)
1	Уурхайн урд тал 0-20см гүнээс	илр	18.7	илр	илр	152.4	24.4	38.9	342.7
2	Уурхайн атобол хойд тал 0-20см гүнээс	илр	18.0	илр	илр	89.4	25.6	27.0	308.6
<b>MNS 5850:2019 /ЗДХ/</b>		<b>3</b>	<b>100</b>	<b>2</b>	<b>150</b>	<b>300</b>	<b>100</b>	<b>50</b>	<b>800</b>

Тайлбар: илр-илрээгүй

Шинжилгээ гүйцэтгэсэн  
Хөрсний хэсгийн инженер

Хянаж баталгаажуулсан  
Хөрсний хэсгийн инженер



Д.Баярхулан

Б.Даваасүрэн

*Зураг 9. Хөрсний хүнд металлын шинжилгээний хариу*

СҮХБААТАР УС ЦАГ УУР, ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ  
Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум 7-р баг  
Утас: 70518201, 94771766  
E-Mail: [sb\\_tsaquur2020@gmail.com](mailto:sb_tsaquur2020@gmail.com)

**ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН**

Дугаар он/код № 2022/08

Сорьц авсан газрын нэр хаяг, утас,: :Сүхбаатар аймаг, Сүхбаатар сум " Дорнын  
чулуулаг "ХХК /Уурхайн орчин/

Сорьц авсан хүний нэр, албан тушаал :БОШЛабораторийн эрхлэгч Н.Мөнхбаяр

Сорьцын хэмжээ, төрөл :Усны сорьц 1.5л-ээр 1ш

Сорьц авсан огноо :2022.09.07

Шинжилгээний аргын стандарт :MNS, MNS ISO

Лабораторид ирсэн :2022.09.08


Шинжилгээ хийсэн огноо :2022.09.09-14


Хуудасны тоо :1/1

Үр дүн:

д/д	Сорьц авсан газар	PH	ЕС	Жинлэгд эх бодис			Ca		Mg		Хатуу лаг	HCO <sub>3</sub>	Cl	
				мг/л	мг/л	мг/экв	мг/л	мг/экв	мг/экв	мг/л			мг/л	мг/э кв
1	Ундны ус	8.32	1499	13.2	40.9	2.04	31.4	2.58	4.62	369	129	3.64		

д/д	Сорьц авсан газар	SO4		NO2	NO3	NH4	P	Fe	F	Пич	Na+K	Эрдэскилт
		мг/л	мг/экв	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	
1	Ундны ус	306.1	6.37	0.022	2.06	0.06	0.248	0.01	1.68	5.6	286	876.4

Шинжилгээ гүйцэтгэсэн техникч:  Б.Саранцэцэг/  
(гарын үсэг) (нэр)

Хянан баталгаажуулсан лабораторийн эрхлэгч:  Н.Мөнхбаяр/  
(гарын үсэг) (нэр)

Зураг 10. Усны химийн шинжилгээний хариу

**АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН  
СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ АЖЛЫН БИЕЛЭЛТ**

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулан БОАЖЯ-ны цахих системээр холбогдох газруудад хүргүүлсэн болно.

## ДҮГНЭЛТ

Манай компани нь 2022 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Тоосжилт ихтэй үед зам усалгааг тогтмол хийж байсан.
- ✓ Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Асгат сумын “Дэлгэр овоо” нэртэй талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэсэн.
- ✓ Хог хаягдлын гэрээ байгуулж, гэрээний дагуу тээвэрлүүлж байсан.
- ✓ Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаар, хөрс, усны шинжилгээ авч лабораторид шинжлүүлсэн.

2022 онд манай компани уулын ажлын төлөвлөгөөндөө хүрч ажиллаж чадаагүй боловч байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр хийгдэх ёстой ажлуудыг цаг тухайд нь хийж гүйцэтгэхийг хичээн ажилласан болно.